

НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСАГ, УЛС ТӨРИЙН ТУЛГАМ АСУУДАЛ

МОНГОЛ, ЗҮҮН ХОЙТ АЗИЙН ОРНУУДЫН ХУДАЛ-
ДАА, ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААЫ
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ ХЭТИЙН ТӨЛӨВ

Ц. Баатар*

Бүс нутгийг хамарсан хамтын ажиллагаа нь хөгжлийн өргөн хүрээтэй боломж агуулдагаараа дэлхийн улс орнуудын сонирхлыг ихээхэн татаж, хөгжлийн цаашдын хандлагын гол чиглэлийг тодорхойлж байна. Тэгээд ч эдийн засгийнхаа хувьд «улс орон» гэхээсээ бүс нутаг гэх нь сүүлийн жилүүдэд улам бүр хүч авч давамгайлах болов.

Монгол улсын Засгийн газар энэ үйл явцын өрнөлтөөс хөдрөхгүйн тулд Мөрийн хөтөлбөртөө Ази, Номхон далайн бүсэд идэвхтэй гадаад бодлого явуулахаар тусгасан билээ. Энэ зорилтыг хэрэгжүүлэх үүднээс тус бүсийн эдийн засгийн байгууллагуудтай хэлхээ холбоо тогтоож үйл ажиллагаанд нь оролцох замаар эдийн засгийн бүсчлэлийн үйл явцад түлхүү оролцох нөхцөл боломжийг бүрдүүлэхэд голлон анхаарч ирлээ.

Өнгөрсөн хугацаанд манай улс худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах давхар татвараас чөлөөлөх тухай зэрэг худалдаа-эдийн засгийн харилцааны эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулж ЗХА-ийн бараг бүх оронтой Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрийг байгуулж, харилцан баталгаажууллаа.

Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмыг үндэслэн аль болох чөлөөтэй, нээлттэй олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх бодлого явуулж ирснээр ЗХА-ийн уламжлалт болон шинэ түншүүдтэй худалдаа-эдийн засгийн харилцааг өргөтгөн хөгжүүлэх таатай боломж бүрдсэн юм.

ЗХА-ийн бүс нутгийн орнуудтай хийж буй худалдааны харилцаанд хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа голлож байна. Гадаад худалдаанд шинэ шинэ түншүүд нэмэгдсээр байгаа боловч хоёр хөрштэй хийж буй худалдаа Монголын гадаад худалдааны 50 гаруй хувийг эзэлсэн хэвээр байна. Өнгөрсөн 1994 онд манай улс 57 оронтой худалдаа хийсэн бөгөөд нийт бараа эргэлт 546 сая. доллар болжээ. Түүнээс ОХУ-д 40, БНХАУ-д 15, Японд 10, АНУ-д 3 хувь нь тус тус ногдож байна.

Гадаад худалдаанд импортлосон барааны 80 хувь нь үйлдвэр техникийн зориулалттай, 20 хувь нь өргөн хэрэглээний бараа эзэлж байна. Экспортод зэсийн баяжмал, хайлуур жоншны баяжмал, ямааны самнасан ноолуур, бөмбөгөн ноолуур, хонь, ямааны арьс үхэр, адууны шир голлож байна. Сүүлийн жилүүдэд БНСУ-тай хийх худалдааны харилцаа өргөжиж байна. Худалдааны уламжлалт харилцаатай

* Ц. Баатар ШУА-ийн Зүүн хойт Ази судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, дэд доктор

БНАСАУ-тай худалдааны харилцааг өргөтгөх тодорхой алхмууд хийж байна.

Өнгөрсөн хугацаанд манай улсын гадаад худалдааны нэг гол төрөл болох жуулчлалын салбарт бүс нутгийн орнуудтай хамтран ажиллах явдал өргөжлөө.

Монгол улсын унаган байгаль, түүх өвөрмөц соёл болон эдийн засаг, нийгмийн хүрээнд өрнөж буй өөрчлөлт нь ЗХА-ийн бүс нутгийн орнууд ялангуяа Япон, Охиод Солонгосын жуулчдын анхаарал сонирхлыг ихээхэн татаж эхэллээ. Манай жуулчид ч бүс нутгийн дээрх орнуудад аялах нь нэмэгдэв.

Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх нь манайд ихээхэн ирээдүйтэй болох нь харагдлаа. Иймд аялал жуулчлалыг хөгжүүлэх асуудлыг төрийн бодлогын хүрээнд авч үзэж түүний материаллаг бааз, дэд бүтэц, боловсон хүчний асуудалд онцгой анхаарч үйлчилгээг дэлхийн жишигт хүргэх зорилт тавигдаж байна.

Дээр өгүүлсэн тоо баримтаас үзвэл манай улс гадаад худалдааныхаа 70 орчим хувийг ЗХА-ийн орнуудтай хийж байгаа тооцоо гарч байна. Харин тийм боловч манай улс ЗХА-ийн бүс нутгийн улс орнуудын гадаад худалдаанд өчүүхэн хувийг эзэлдэг. Энэ бүсийн орнуудын худалдаа, эдийн засгийн харилцан шүтэлцээнд нөлөөлөх, боломж хязгаарлагдмал хэвээр байна. Тийм учраас зах зээлийн боломжоо харгалзан ЗХА-ийн бүс нутгийн орнуудын худалдааны нэгдсэн сүлжээ бий болгоход чиглэсэн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байгаа билээ. Мөн түүнчлэн манай улс дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүний хувьд олон улсын худалдааны гол гол асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэдэг тариф, худалдааны Ерөнхий Хэлэлцээр (ГАТТ)-д нэгдэн орох улмаар Дэлхийн худалдааны байгууллагын (ДХБ)-ын гишүүн болох зорилт тавьж байна. Ингэснээр Монгол улс гишүүн бүх орны худалдааны нэн тааламжтай нөхцөлийг эдлэх, манай барааны зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, бусад орноос манай экспортын бараанд ногдуулдаг импортын тарифын бус хориг саадыг хэлэлцээний үр дүнд багасгах, хоёр талын шугамаар үүссэн маргаантай асуудлыг ДХБ-шугамаар хянан шийдвэрлүүлэх, ДХБ-д явагддаг яриа хэлэлцээнд оролцож өөрийн орны эрх ашгийг хамгаалах, туршлага судлах зэрэг ач холбогдолтой юм.

ЗХА-ийн зарим орон тухайлбал ОХУ, БНХАУ, Япон зэрэг орнууд манай улсын гадаад худалдааны үйл ажиллагааг дэмжиж импортын тарифын бус хориг саадыг хэлэлцээний үр дүнд багасгахад чиглэсэн нааштай бодлого баримталж байна.

АНУ манай улсад үйлдвэрлэсэн сүлжмэл, оёмол эдлэлийг өөрийн зах зээлд оруулахад ямар нэгэн тооны хязгаарлалт татвар оногдуулахгүй байх худалдааны нэн тааламжтай нөхцөл олгосон юм.

Япон улс өөрийн санаачилгаар Азийн Худалдаа Дэмжих Байгууллагуудын чуулганы ээлжит IX хуралдааныг 1995 оны наймдугаар сард Улаанбаатар хотноо хуралдуулав. Энэ нь бүс нутгийн худалдааг хөгжүүлэхэд Монголын оролцоог нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой боллоо.

Энэ байгууллага, Дэлхийн худалдаа ихээхэн өрсөлдөөнтэй

өнөө үед тухайн бүс нутгийн улс орны бүтээгдэхүүний тэр өрсөлдөөнийг даван туулахад нь мэргэжлийн туслалцаа үзүүлж, боловсон хүчин сургахад нь дэмжлэг үзүүлдэг ажээ. Одоо тус байгууллага гадаадынхан Монголд хөрөнгө оруулахад нь дэмжиж Монголын байдлыг тэдэнд ойлгуулах чиглэл баримталж байна.

Манай улс гадаадын хөрөнгө оруулах тухай хуулийг шинэчлэн баталж 1993 оны 7 дугаар сарын 1-ээс мөрдөж ирэв. Энэ хуулиар гадаадын хөрөнгө оруулалтын баталгаа, хамгаалалт, гадаадын хөрөнгө оруулагчийн эрх зүйн талаар олон улсын хэмжээнд мөрддөг нийтлэг журам ёсыг бататгахын зэрэгцээ Монгол орны өвөрмөц хүчин зүйл байршил, дэд бүтэц, зам харилцаа нөөц баялаг, ажиллах хүчин, зах зээлийн багтаамж зэргийг харгалзан гадаадын хөрөнгө оруулах таатай нөхцөлийг аль болох бүрдүүлэхэд чиглэсэн юм.

1995 оны нэгдүгээр сарын 1-ний байдлаар 1990 оноос хойш гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж (ГХО ААН) байгуулах зөвшөөрлийг 388 нэгж авсан байна. Тэд гадаадаас нийтдээ 14.8 сая. ам. долларын хөрөнгө оруулах юм. Зөвшөөрөл авсан ГХОААН-ээс 191 аж ахуйн нэгж оруулбал зохих хөрөнгөө оруулж улсын татварын ерөнхий газарт бүртгүүлж, аж ахуйн нэгжийн гэрчилгээ авч үйл ажиллагаагаа явуулж байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын байдлаас үзэхэд түүний ихэнх хэсгийг ЗХА-ийн орнууд эзэлж байна. Түүний дотор хөрш хоёр улс толгой цохиж байна. Тухайлбал, ОХУ-тай 143, БНХАУ-тай 1266, Япон 20, БНСУ 9, АНУ-тай 14 хамтарсан компани байгуулах зөвшөөрлийг тус тус авсан байна.

Байгуулагдахаар зөвшөөрөл авсан ГХОААН-ийн 36.2 хувь нь ОХУ-тай, 31,8 хувь нь БНХАУ-тай, 5,1 хувь нь Японтой, 3,5 хувь нь АНУ-тай, 2,3 хувь нь БНСУ-тай байгуулагдахаар тохиролцжээ.

Гадаадын хөрөнгө оруулагчийн хувь хөрөнгийн бүрдэлтээс гэвэл Орос 27,4 хувь, Хятад 19,5 хувь, АНУ 16,5 хувь, Япон 3,5 хувь, Өмнөд Солонгос 7,5 хувийг тус тус эзэлж байна. ГХОААН байгуулахаар зөвшөөрөл авсан хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд нь үйлдвэрлэл, үйлчилгээний 23 чиглэлээр өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулах юм. Энэхүү хүрээнд худалдаа оёдол, сүлжмэл, хүнсний зүйл үйлдвэрлэл, төрөл бүрийн судалгаа, шинжилгээ хийх, жуулчин, нийтийн хоолны үйлчилгээ явуулах ашигт малтмал олборлох, судлах үйл ажиллагаа давамгайлж байгаа болно.

Судалгаанаас үзэхэд уламжлалт түнш, хөрш Орос, Хятадын хөрөнгө оруулагчдын тоо, хөрөнгийн хэмжээ урьдын адил зонхилж байгаа боловч АНУ, Япон БНСАУ-ын хөрөнгө оруулалт идэвхжиж эдгээр орны хөрөнгө оруулагчид нь байгалийн баялаг эрэх, боловсруулах ашиглах болон өндөр технологийн салбарт харьцангуй их хэмжээний хөрөнгө оруулалт хийх хандлагатай байна.

ЗХА-ийн бүс нутгийн хамтын ажиллагаанд Монголын оролцох боломж нөхцөлийн талаар орон орны судлаачид, шинжээчид янз бүрийн санал дэвшүүлж байна. Тухайлбал, АНУ-ын Гавайн Дорнод-өрнөд төвийн судлаач Б. Кампвел Монгол улс-бүс нутгийн хамтын ажиллагаанд уламжлалт арьс ширэн бүтээгдэхүүний зэрэгцээ шилний үйлдвэрлэлээр

түлхүү оролцох боломжтой гэж үзэж байна. Японы судлаач Такаши Сугимото Зэс болон бусад байгалийн эрдэс баялагт гүн боловсруулалт хийх, аялал жуулчлалыг онцгой анхаарах нь цаашдын хамтын ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна. БНСУ-ын судлаач Нарк Ён Ань Монголд юуны өмнө боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудалд түлхүү анхаарч энэ чиглэлээр ЗХА-ийн орнуудтай тэр дундаа Өмнөд Солонгостой нягт хамтран ажиллаж Солонгосын техник, технологийг ашиглах явдал чухал. Ингэснээр бүс нутгийн зах зээлд эрэлт ихтэй бүтээгдэхүүнийг хамтарч гаргах өргөн боломжтой гэсэн санал дэвшүүлж байна. Энэ мэтчилэн олон орны эрдэмтэд Монгол улсын гео-улстөр-гео-эдийн засаг, гео-стратегийн байдлыг нарийвчлан судалж аль салбарт, ямар чиглэлээр Монголтой хамтран ажиллах боломж нөхцөлтэй, ирээдүйтэй болохыг засгийн газрын болон засгийн газрын бус байгууллагууддаа зөвлөмж болгож байна.

Монгол хөрөнгө оруулахад хамгийн ашигтай зах зээл мөн үү? гэдэг асуудлыг чухам ингэж тал бүрээс нь нягтлан судалж буй нь тэдгээр орны хувьд зүйн хэрэг биз ээ. Манай улс дэлхийн зам харгуйгаас зайдуу, зах зээлийн багтаамж бага, дэд бүтэц хөгжөөгүй, эдийн засгийн хөгжил сул зэрэг хүчин зүйлс гадаадын хөрөнгө оруулалтанд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна. Энэ байдлаас болж өнгөрсөн хугацаанд дорвитой хөрөнгө оруулалт үндсэндээ хийгдсэнгүй.

Хөгжлийн томоохон асуудлуудыг гагцхүү харилцан ашигтай хамтын ажиллагааны хүрээнд л шийдвэрлэдэг билээ.

Шилжилтийн үеийн хүнд байдлаас гарахад өрнө-дорнын олон орон манай улсад сэтгэл харамгүй тусалж байгаа билээ. Эдийн засгийн бэрхшээлийг даван туулахад шаардлагатай нэг чухал нөхцөл болох энэхүү тусламж дэмжлэг үзүүлж байгаа орнуудын дотор ЗХА-ийн бүс нутгийн орнууд тодорхой байр суурь эзэлж байна.

Монголд хандивлагчдын хөдөлгөөн өрнөсөн 1991 оноос 1995 он хүртэл Япон улс 138 сая 162.3 мянга, АНУ 67 сая 475 мянга, БНСУ 4 сая 800 мянга, БНХАУ 3 сая 777 мянган ам. долларын буцалтгүй тусламж тус тус үзүүлсэн юм. Мөн хугацаанд Япон улс 82 сая 25 мянга, БНСУ 5 сая 200 мянга, БНХАУ 5 сая 500 мянга, ОХУ 38 сая 669 мянган ам. долларын хөнгөлөлттэй зээл тус тус олгоод байна. Манай улсад үзүүлсэн нийт зээл тусламжийн гуравны нэг орчим хувийг Азийн гол хандивлагч орон болох Япон улсын зээл тусламж эзэлж байна.

Сүүлийн хэдэн жилд манай улс эдгээр зээл тусламжийг чиглэсэн зорилготой, эргээд үр дүн өгөх эдийн засгийн хөгжлийн бааз суурийг бүрдүүлэх төсөл, арга хэмжээнд зориулж байна.

Япон улс манай орны дэд бүтцийг хөгжүүлэхэд зээл тусламжийнхаа ихээхэн хэсгийг зориулж байна. Үүнийг цаашдаа Японы хөрөнгө оруулалт, үйлдвэр Монголд орж ирэх суурь баазыг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ гэж ойлгож болох юм. Нөгөө талаар энэ нь Япон улс Монгол оронтой хамтран ажиллах нь ашигтай, нэлээд ирээдүйтэй гэж үзэж буй нь нэг бодитой илрэл болж байна.

Сүүлийн үед Ази, Номхон далайн бүсэд ихээхэн нөлөө.

бүхий Япон, Өмнөд Солонгосын Иточу, Самсунг, Хюндай мотор зэрэг шилдэг нүүс, компаниуд сонирхож эхэллээ.

Өнөөгийн практикаас үзэхэд манайхан түншээ сайн судалж, сонгож чадаагүй үйл ажиллагааныхаа чиглэлийг оновчтой тогтоогүйгээс болж алдаж осолдох явдал гарсаар байна. Ийм нөхцөлд төр засгийн зүгээс энэ талын тусламж дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах асуудал чухал юм.

Өнгөрсөн хугацаанд Засгийн газраас ЗХА-ийн бүс нутгийн орнуудтай хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлж, иргэд хоорондоо харилцан зорчих, худалдаа эдийн засгийн харилцааны тааламжтай орчин бүрдүүлэхэд чиглэсэн тодорхой алхмууд хийж ирэв. Тухайлбал 1995 оны зургадугаар сард болсон Монгол улс, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад улсын Засгийн газар хоорондын комиссын II хуралдаанаас Алтанбулагт худалдаа эдийн засгийн чөлөөт бүс бий болгох, иргэдийн харилцан зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тэнд шалган нэвтрүүлэх цогцолбор барих асуудлыг ярилцаж тохиролцов. Мөн Монгол улс, Эрхүү, Чита, Якут, Тува, Горный Алтайн муж улсууд нийлээд бүс нутгийн хамтын ажиллагааны механизм бий болгох нь зүйтэй гэж үзсэн байна.

Одоо энэ чиглэлээр манай талын комисс байгуулагдаж ажиллаж байна. Түүнчлэн манай Дорнод бүсийн зүүн гурван аймаг Чита мужийн хамтын ажиллагааг хөгжүүлэх ялангуяа эдийн засаг, аж ахуйн өдөр тутмын харилцааг өргөжүүлэхэд чиглэсэн харилцан шийдвэрлэх олон асуудлыг ярилцаж тохироод байна.

Урьд хөрш Хятадтай хил залгаа аймгуудын хамтын ажиллагаанд ч нэлээд ахиц гарав. Одоо манай улсын Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь, Говь-алтай, Ховд Баян-өлгий зэрэг аймгууд хил залгаа Хятадын Өвөр Монгол, Шинжааны өөртөө засах орнуудын аймгуудтай шууд харилцдаг болж хилийн худалдаа хөгжиж, хоёр талын хамтын ажиллагаа өргөжин тэлж байна.

1995 оны эхний хагаст Улаанбаатар хотноо Олон улсын бизнес, хамтын ажиллагааны нийгэмлэг байгуулагдлаа.

Монголын «Таван эрдэнэ», «Эм хангамж», Барилгын материал хангамжийн компани, ОХУ-ын Москва, Санкт Петербург, Эрхүү, Улаан-Үд хотын «Визит», «Туга», «Целлиод», «Шанхай Хөх» хотын аялал жуулчлал, бараа хангамж тоног төхөөрөмжийн үйлдвэр зэрэг байгууллага нэгдэн нийм нийгэмлэг байгуулжээ. Улаанбаатарт төвтэй, Улаан-Үд, Хөх хотод салбартай энэ нийгэмлэг нүүс, компани, ажил хэрэгч хүмүүст зуучлан мэдээллийн найдвартай сүлжээ бий болгох, бизнес сургалт, үзэсгэлэн яармаг зохион байгуулах ажээ. Энэ бүхнийг хоёр талын харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлэх тааламжтай нөхцөл бий болгоход чиглэсэн тодорхой алхмуудын нэг гэж үзэж болох юм.

Ийнхүү Монгол улс Зүүн хойт Азийн орнуудтай худалдаа, эдийн засгийн талаар хамтран ажиллаж эхэлж байгаа нь олон талын ач холбогдолтой юм. Энэ нь Монголын эдийн

засгийг өнөөгийн хүнд байдлаас гаргах, бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд Монголыг татан оруулах, манай улсад шинэ техник технологид үндэслэсэн үйлдвэрлэлийн зарим салбарыг хөгжүүлэхэд бодитой тус дөхөм үзүүлэх юм гэж бид үзэж байна.

1. Зах зээл 1995, №13, 14
2. Зах зээл 1995 №15, 166
3. Northeast Asia Economic Forum newsletter.
1993. N 5, p. 4.
4. Rethinking development strategy in Northeast Asia
Edited by Sumio Kuribayashi. Japan, 1993, p. 65—81.
5. The role of North-East Asia in the New World Order,
Seoul, 1993, p. 151—164.
6. «Ардын эрх» 1995 З. 13. №47